



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/57

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “а”, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдаас төв суурин газарт ирж буй малын гаралтай бүтээгдэхүүн болон аймгийн хэмжээний мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг хүнсний зах худалдааны төв, супер маркет, худалдааны агуулах, мах ангилан савлах үйлдвэр, цехийн үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Н.Бямбадорж – Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Нарийн бичгийн дарга Л.Оюун-Эрдэнэ- Мал эмнэлгийн газрын дарга

Гишүүд Б.Оюутболд- Аймгийн Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа

Б.Биндэръяа- Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

С.Сайнхүү- Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Ц.Насанбаяр- Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ч.Гомбодорж- Аймгийн Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн дарга


2.Сумдаас төв суурин газарт ирж буй малын гаралтай бүтээгдэхүүн болон аймгийн хэмжээний мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг хүнсний зах, худалдааны төв, супер маркет, худалдааны агуулах, мах ангилан савлах үйлдвэр, цехийн үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгах үйл ажиллагааг 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдөр хүртэл зохион байгуулсугай.

1210145

2.

3.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж 03 дугаар сарын 05-ны дотор танилцуулахыг ажлын хэсэг /Н.Бямбадорж/-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Т.Хишигбаатар/-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

